



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐21 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 119

Сүмбэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 2, 3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 04 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг Нягтлан бодогч Алтансүхийн Золбаяр, Жолооч Батсуурийн Баярцэнгэл, Лабораторийн химич шинжээч Даваасүрэнгийн Гантуяа, Архив, бичиг хэрэг, мэдээлэл технологийн ажилтан Баттогтохын Урангоо нарт албан тушаалын үндсэн цалингийн 25 хувиар, Лабораторийн эрхлэгч Цэрэнбаярын Шагдаржавд албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг А.Золбаяр 180211 (нэг зуун наян мянга хоёр зуун арван нэг), Б.Баярцэнгэлд 142396 (нэг зуун дөчин хоёр мянга гурван зуун ерэн зургаа), Д.Гантуяа 177440 (нэг зуун далан долоон мянга дөрвөн зуун дөч), Б.Урангоо 144483 (нэг зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун наян гурав) Ц.Шагдаржав 151432 (нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийг тус тус бодож олгохыг нягтлан бодогч /А.Золбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ГАНБАЯР.

